

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2017 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн  
Дөрөвдүгээр хуралдааны 01 дүгээр  
тогтоолын хавсралт

**“ХӨГЖЛИЙН ТҮҮЧЭЭ-ТӨВ АЙМАГ-2024”  
АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ.**

**УДИРТГАЛ:**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: “ХӨГЖЛИЙН ТҮҮЧЭЭ-ТӨВ АЙМАГ-2024” ХӨГЖИЙН  
ХЭТИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД**

**1.1. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**

- 1.1.1. Эдийн засгийн бодлого
- 1.1.2. Хөдөө аж ахуйн салбар
- 1.1.3. Аж үйлдвэр, үйлчилгээ, аялал жуулчлалын салбар
- 1.1.4. Дэд бүтцийн салбар

**1.2. НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**

- 1.2.1. Хүн амын эрүүл мэндийн салбар
- 1.2.2. Боловсрол, соёл, урлагын салбар
- 1.2.3. Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

**1.3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**

**1.4. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАСАГЛАЛ**

- 1.4.1 Нутгийн удирдлага
- 1.4.2 Хууль, хяналт

**ХОЁРДУГААР БҮЛЭГ: ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙН  
ЗОХИЦУУЛАЛТ, ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ**

- Хяналт, үнэлгээ
- Бодлогын хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

**“ХӨГЖЛИЙН ТҮҮЧЭЭ-ТӨВ АЙМАГ-2024”  
АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТЫН ТОВЧОО**

<b>№</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Зорилгын тоо</b>	<b>Зорилтын тоо</b>
1	Эдийн засгийн тогтвортой хөгжил	11	58
2	Нийгмийн тогтвортой хөгжил	7	14
3	Байгаль орчны тогтвортой хөгжил	1	7
4	Тогтвортой хөгжлийн засаглал	3	24
	<b>НИЙТ</b>	<b>22</b>	<b>103</b>

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: “ХӨГЖЛИЙН ТҮҮЧЭЭ-ТӨВ АЙМАГ-2024” АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

**АЛСЫН ХАРАА:** НИЙТ ӨРХИЙН ДИЙЛЭНХИЙГ ДУНДАЖ БА ДУНДЖААС ДЭЭШ АМЬДРАЛТАЙ БОЛГОХОД ЧИГЛЭНЭ.

**ЭРХЭМ ЗОРИЛГО:** ХҮНЭЭ ЭРХЭМЛЭН ДЭЭДЭЛСЭН, БАЙГАЛЬ ОРЧИНД ЭЭЛТЭЙ, ЗАХ ЗЭЭЛД ӨРСӨЛДӨХ ЧАДВАРТАЙ, ӨНДӨР ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ДАВАМГАЙЛСАН, ТОГТВОРТОЙ ӨСӨЛТТЭЙ, ӨӨРИЙГӨӨ ТЭТГЭХ, ОНОВЧТОЙ БҮТЭЦ БҮХИЙ ЭДИЙН ЗАСАГТАЙ АЙМАГ БОЛОХОД ОРШИНО.

### 1. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

#### 1.1 Эдийн засгийн бодлого

**ЗОРИЛГО 1:** Аймгийн эдийн засгийн салбарын бүтцийг төрөлжүүлж, төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгож, батлагдсан төсвийг чанд мөрдөж, төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, өндөр бүтээмжтэй, дэвшилтэт технологийг салбар бүрт нэвтрүүлэх, инноваци шингэсэн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих замаар хөрөнгө оруулалтын өгөөжийг дээшлүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгоно.

**Зорилт 1:** Аймгийн эдийн засгийн бүтэц дэх боловсруулах үйлдвэр, үйлчилгээний салбарыг дэвшилтэт технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ.

#### **Нэгдүгээр үе шат (2017-2020 он):**

-Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлтийг 8-аас доошгүй хувиар ханган, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх.

#### **Хоёрдугаар үе шат (2021-2024 он):**

-Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлтийг 12-оос доошгүй хувиар ханган, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх.

**Зорилт 2:** Бүс нутаг болон сумдын жигд хөгжлийг хангана.

#### **Нэгдүгээр үе шат (2017-2020 он):**

-Сумдын эдийн засаг, нийгмийн суурь судалгаануудыг нарийвчлан гаргаж, хөгжлийн түвшинг тодорхойлох аргачлалыг шинээр боловсруулж батлан, хэрэгжүүлж эхлэх.

#### **Хоёрдугаар үе шат (2021-2024 он):**

-Сумдын хөгжлийн түвшинг үндэслэн төсөв, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг оновчтой хуваарилан, төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх.

**Зорилт 3:** Бүхий л салбарт гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх санал санаачилгыг дэмжиж, бизнесийн таатай орчин бүрдүүлэх бодлогыг баримтлан ажиллана.

#### **Нэгдүгээр үе шат (2017-2020 он):**

-Эдийн засгийн хөгжилд гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татах таатай орчинг бүрдүүлж, хамтарсан үйлдвэр байгуулах, тоног төхөөрөмж худалдан авах хэлбэрээр өндөр технологи болон орчин үеийн менежментийг нутагшуулах, нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах.

#### **Хоёрдугаар үе шат (2021-2024 он):**

- Бүтээмж өндөртэй, үр ашигтай, эдийн засгийн тэргүүлэх салбаруудын технологи, гадаадын дэвшилтэт технологиудыг судлах, төсөл боловсруулж хэрэгжүүлэх, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог эрс нэмэгдүүлэх.

**Зорилт 4: Бүх үе шатанд (2017-2024 он):** Төсвийн ил тод байдал, сахилга хариуцлагыг дээшлүүлнэ.

**Зорилт 5: Бүх үе шатанд (2017-2024 он):** Татварын орлогын тогтвортой эх үүсвэрийг бий болгож, ажлын байрыг нэмэгдүүлэх, хөнгөн үйлдвэр, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжинэ.

**Зорилт 6:** Аймагт хөрөнгө оруулалт болон үнэт цаасны зах зээлийг шинээр нэвтрүүлж, санхүүгийн зах зээлийн цар хүрээг өргөтгөн, иргэдийг хөрөнгийн зах зээлээс үр ашиг хүртэх боломжийг бүрдүүлнэ.

**Нэгдүгээр үе шат (2017-2020 он):**

-Иргэд, аж ахуйн нэгжийг үнэт цаасны зах зээлд итгэх итгэлийг нэмэгдүүлэн, зах зээлийн талаарх мэдлэг мэдээллийг дээшлүүлэх.

**Хоёрдугаар үе шат(2021-2024 он):**

-Иргэд, хувийн хэвшлийн оролцоотойгоор орон нутгийн аж ахуйн нэгж байгуулан, хөрөнгийн зах зээлээс хувь ашиг хүртэх нөхцлийг хангах.

**Зорилт 7: Бүх үе шатанд (2017-2024 он):** Аймгийн нийгэм, эдийн засгийн статистик мэдээллийн магадлалыг сайжруулж, санг баяжуулан, боловсронгуй болгож, төлөвлөлт, хяналт, удирдлагын хэрэглэгдэхүүн болгоно.

**ЗОРИЛГО 2:** Эдийн засаг, бизнес, өмчийн харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгоно.

**Зорилт 1:Бүх үе шатанд (2017-2024):** Төр-хувийн хэвшлийн түншлэлийг сайжруулж, дэд бүтцийн болон нийгмийн салбарт хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг концессоор хэрэгжүүлнэ.

**Зорилт 2:Бүх үе шатанд (2017-2024):** “Шилэн тендер шалгаруулалт” бодлогыг хэрэгжүүлнэ.

## **1.2.Хөдөө аж ахуйн салбар**

**ЗОРИЛГО 1:** Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хөгжлийн бодлогыг боловсронгуй болгож, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицсон бэлчээрийн малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, бэлчээрийн даацад нийцсэн мал сүргийн тоо, бүтцийн зохистой харьцааг бүрдүүлэх, бэлчээрийн газрын доройтлыг бууруулж, нөхөн сэргээх, мал амьтны өвчний тандалт, хяналт, үйлчилгээний технологит хугацааг баримтлан, шинжлэх ухааны ололт, тэргүүн туршлагыг нэвтрүүлэн, ажиллагсдын хөдөлмөрийн бүтээмж, үнэлэмжийг ахиулан үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан, олон улсын стандартад нийцсэн ХАА-н бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлж, малчдынхаа бодит орлого, амьдралын түвшинг дээшлүүлж, зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ.

**Зорилт 1:** Уламжлалт бэлчээрийн малын үүлдэр угсааг нутгийн шилмэл омог, үүлдрээр сайжруулах, тэжээлийн баазыг түшиглэн тодорхой бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэн, цэвэр эрлийз, цөм сүрэг, өндөр ашиг шимт малын сүрэгт эзлэх хувийн жинг 10-аас доошгүй хувьд хүргэж, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

-Хонийг: мах, ноосны чиглэлээр, ямааг: ноолуур, сүүний чиглэлээр, адууг: хурдны болон махны чиглэлээр, үхрийг: мах, сүүний чиглэлээр сайжруулах, судалгаа, шинжилгээ (ямаа, адууны бэлдмэлүүд, адууны калыц) хийх туршилтын баазыг бий болгон ажиллуулах.

-Франц улсын Монбиллиард үүлдрийн сүүний үхрийн кластерийн загвар аж ахуй байгуулах.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Туршилтын үр дүнд нэгжээс авах ашиг шимийг нэмэгдүүлэх. Баянцагаан нутгийн илүү нугаламт хонин сүрэгт эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэдтэй хамтран ангилалт, шилэн сонголт, ашиг шимийн хэмжилтүүд, үржлийн ажлын судалгаанууд хийлгэсний үндсэн дээр улсын хэмжээнд омог болгон баталгаажуулах.

**Зорилт 2.** Бэлчээрийн даацад тохируулан малын тоо толгойг тогтвортой барих бодлого хэрэгжүүлж, сүргийн бүтэц, төрлийн зохистой харьцааг бүрдүүлж, бэлчээрийн монгол малыг уламжлалт селекцийн аргаар шилэн сонгож, өөр дотор нь үржүүлж генфондыг нь хадгална.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

- Аймгийн эдийн засгийн бүс болон сум тус бүрээр бэлчээрийн хэмжээ, даацад нь нийцсэн сүргийн бүтэц, малын тооны оновчтой хэмжээг шинжлэх ухааны байгууллагатай хамтран тогтоож, баг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх зохих шийдвэр гаргуулах, уг шийдвэрийг үе шаттайгаар тодорхой төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж эхлэх.

-Нийт мал сүрэгт эзлэх ямааны хувийн жинг 31.5 хувь, адууны хувийн жинг 8 хувь болгон бууруулах, үхэр, хонь, тэмээний эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх.

-Нутгийн монгол хонины дотор элит, шилмэл хонины эзлэх хувийн жинг 30 хувьд хүргэх, ямааны ноолуурын гарцыг одоогийн түвшнээс 30 хувиар нэмэгдүүлэх.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

- Нийт мал сүрэгт эзлэх ямааны хувийн жинг 29,2 хувь болгон бууруулах, адууг 8 хувьд тогтвортой байлгаж, үхэр, хонь, тэмээний эзлэх хувийн жинг нэмэгдүүлэх.

-Нутгийн монгол хонины дотор элит, шилмэл хонины эзлэх хувийн жинг 50 хувьд, ямааны ноолуурын гарцыг 40 хувьд хүргэж, нэмэгдүүлэх.

**Зорилт 3. Бүх үе шатанд (2017-2024):** Мал сүргийг байгалийн болзошгүй эрсдлээс хамгаалж, сум дундын болон тухайн сум доторх отрын бүс нутгийн хэмжээг нэмэгдүүлж, өвс тэжээлийн нөөц бүрдүүлнэ.

**Зорилт 4. Бүх үе шатанд (2017-2024):** Уламжлалт бус аж ахуй, түүнд хамрагдах амьтдын тоог өсгөж, бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн хэмжээг 14-өөс доошгүй хувиар нэмэгдүүлнэ.

**Зорилт 5. Бүх үе шатанд (2017-2024):** Биотехнологийн дэвшилтэт арга хөврөл үр шилжүүлэн суулгах, малын зохиомол хээлтүүлгийг өндөр ашиг шимт хээлтүүлэгч малын гүн хөлдөөсөн үр ашиглах замаар 12.0 мянган үнээнд зохиомол хээлтүүлэг, 900 үнээнд хөврөл үр суулган үйл ажиллагааг өргөжүүлж ашиг шим өндөртэй малын тоо толгойг нэмэгдүүлнэ.

**Зорилт 6. Бүх үе шатанд (2017-2024):** Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн байгууллагын мэдэлд авах ажлыг дэс дараатай зохион байгуулж, 2024 онд 100 хувь мэргэжлийн байгууллагын хяналтан дор үйл ажиллагааг явуулна.

**Зорилт 7:** Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлж, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, бэлчээр усжуулалтыг нэмэгдүүлнэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

- Бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулан, багийн иргэдийн нийтийн хурлаар батлуулж, хэрэгжилтийг хангуулж ажиллах.

- Тал хээрийн сумдын баг бүрт жилд хоёроос доошгүй худаг гаргаж, бэлчээр усжуулалтыг 71-ээс доошгүй хувьд хүргэх,

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

- Бүх сумдад жилд 2-оос доошгүй худаг гаргаж, бэлчээр усжуулалтыг 74-ээс доошгүй хувьд хүргэх,

**Зорилт 8:** Нутгийн шилмэл үүлдэр, омгийн болон өндөр ашиг шимт малын шалгаруулалт, үзэсгэлэн, дуудлага худалдаа зохион байгуулах цогцолбор байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.

**Нэгдүгээр үе шатанд (2017-2020):** Малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулах цогцолбор байгуулах.

**Хоёрдугаар үе шатанд (2021-2024):** Байнгын тогтвортой үйл ажиллагаатай болох.

**Зорилт 9: Бүх үе шатанд (2017-2024):** Өсөн нэмэгдэж байгаа зах зээлийн эрэлт, хэрэгцээг харгалзан “Мах сүүний аян”-ыг өрнүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг сум орон нутгийн түвшинд хөгжүүлэх, “Эрүүл хүнс-Эрүүл монгол” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлнэ.

**Зорилт 10: Бүх үе шатанд (2017-2024)** Хөдөө аж ахуй дахь хамтын нөхөрлөлийг сайжруулж хөдөө аж ахуйн бүлэг, хоршоо байгуулахыг дэмжиж, хөдөө аж ахуйн хоршоодын үйл ажиллагаанд мониторинг үнэлгээ хийж, дүгнэлт өгч, хоршоог цаашид хөгжүүлэх шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

**ЗОРИЛГО 2:** Мал, амьтны эрүүл мэндийг баталгаажуулж, 2020 онд халдварт өвчингүй аймаг, 2024 он гэхэд “**Мал амьтны гоц халдварт, халдварт өвчлөлгүй-Эрүүл бүс нутаг**” болж улмаар аймаг орон нутаг болон Монгол Улсын экспортод гаргах боломжийг нэмэгдүүлэх, олон улсын стандартад нийцсэн мал эмнэлгийн тогтолцоотой болно.

**Зорилт 1: Бүх үе шатанд (2017-2024):** Гоц халдварт шүлхий, цэцэг өвчнөөр тайван бүс нутгийн статусыг хангаж, малчид болон мал бүхий иргэдийн мал эмнэлгийн талаархи мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулж хэрэгжүүлнэ.

**Зорилт 2: Бүх үе шатанд (2017-2024):** Халдварт, паразиттах өвчний урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологит хугацаанд зохион байгуулах, мал эмнэлгийн бүх нэгжийг стандартын шаардлага хангуулж, мал эмнэлгийг чадавхижуулж, ажил үйлчилгээний шуурхай нэгдмэл байдлыг ханган чанар хүртээмжийг сайжруулна.

- Мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхэлж буй төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн ажиллах нөхцөл бололцоог боловсронгуй болгох, дэмжлэг туслалцаа үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах, малын эмч нарын залуу халааг бэлтгэх, мэргэжлийн сургалтад хамруулж, мэдлэг ур чадварыг дээшлүүлж, ажлын хариуцлагыг дээшлүүлнэ.

**Зорилт 3: Бүх үе шатанд (2017-2024):** Мал эмнэлэг ариун цэврийн магадлан шинжилгээний ажлыг боловсронгуй болгож, мал эмнэлгийн лабораторийг олон улсын стандартад нийцүүлэн, аймаг, орон нутгийн лабораторийн оношилгоо, шинжилгээний чадавхийг сайжруулна.

**Зорилт 4: Бүх үе шатанд (2017-2024):** Мал эмнэлгийн ажил үйлчилгээг малчны хотонд үзүүлэх стандарт хангасан “Нүүдлийн мал эмнэлэг” төсөл хэрэгжүүлэх, малчдын хөрөнгө санхүүгийн оролцоотой мал эмнэлгийн нэгжийг байгуулах үүсэл санаачилгыг дэмжинэ.

**ЗОРИЛГО 3:** “Атрын III аян”-ыг үргэлжлүүлэн тариалангийн газрыг эдийн засгийн эргэлтэд оруулж хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэн бүтээгдэхүүний чанар, нэгжээс авах ургацыг нэмэгдүүлнэ.

**Зорилт 1:** “Атрын III аян”-ыг эрчимжүүлж, Үр”, “Уринш бордоо, ургамал хамгаалал”, “Хүнсний ногоо”, “Техник шинэчлэл, боловсон хүчний хангалт”, “Малын тэжээл бэлтгэл, үйлдвэрлэл” дэд хөтөлбөрийг багтаасан Аймгийн газар тариалангийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

- Байгаль цаг уурын нөхцөлд дасан зохицсон сорт, технологийн шинэчлэл, эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг шинжлэх ухааны үндэслэлтэй нэвтрүүлж, нэгж талбайн ургацыг нэмэгдүүлэх, тариалангийн талбайн ашиглалтыг сайжруулах, аж ахуйн нэгжүүдийн бизнесээ өргөжүүлэх боломжийг дэмжих замаар тогтвортой газар тариалан эрхэлж, буудай 85.0 мянган га-д тариалж, нэгжээс 17.3 цн, төмс 6.1 мянган га-д тариалж, нэгжээс 155 цн, хүнсний ногоо 1.6 мянган га-д тариалж, 147 цн, тэжээлийн ургамал 9.5 мянган га-д тариалж, нэгжээс 23 цн хураан авч дотоодын хэрэгцээг бүрэн хангах.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/**

- Буудай 104.0 мянган га-д тариалж, нэгжээс 19 цн, төмс 6.2 мянган га-д тариалж, нэгжээс 175 цн, хүнсний ногоо 1.6 мянган га-д тариалж, 180 цн, тэжээлийн ургамал 12.0 мянган га-д тариалж, нэгжээс 35 цн ургац хураан авч, дотоодын хэрэгцээг бүрэн хангах.

**Зорилт 2:** Тариалангийн талбайг эдийн засгийн эргэлтэд оруулан, ашиглалтын түвшинг нэмэгдүүлнэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

- Эдийн засгийн эргэлтэнд оруулах тариалангийн талбайн ашиглалтыг 86-аас доошгүй хувьд хүргэх.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/**

- Эдийн засгийн эргэлтэнд оруулах тариалангийн талбайн ашиглалтыг 98-аас доошгүй хувьд хүргэх.

**Зорилт 3: Бүх үе шатанд (2017-2024):** Гангийн эрсдэлийг бууруулах зорилгоор усалгаатай газар тариалангийн үйлдвэрлэлийг бүхий л талаар дэмжиж, орон нутгийн онцлогт зохицсон эрчимжсэн агро-технологи нэвтрүүлэн, усалгаатай тариалангийн хэмжээ болон ургацын бүтээмжийг нэмэгдүүлнэ.

**Зорилт 4: Бүх үе шатанд (2017-2024):** Үр тариа, төмс, хүнсний ногооны үрийн үйлдвэрлэлийг хөгжүүлж эрдэм шинжилгээний байгууллагыг түшиглэн, техник, технологи, аж ахуй, санхүүгийн боломжтой аж ахуйн нэгж, тариалан эрхлэгчдийн бизнесийн сонирхолтой хослуулан, зээлийн дэмжлэг үзүүлэх замаар сайн чанарын үрийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үрийн хэрэгцээг бүрэн хангах, үр үржүүлгийн аж ахуйн нэгж байгуулна.

**Зорилт 5: Бүх үе шатанд (2017-2024):**Хамгаалагдсан болон хучлагатай тариалан, өрхийн тариалан эрхлэлтийг дэмжин шинэ техник, технологи нэвтрүүлж механикжуулах, төрөлжсөн зоорийн аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногооны үйлдвэрлэлийг 2 дахин нэмэгдүүлнэ.

**Зорилт 6: Бүх үе шатанд (2017-2024):** Таримлын сэлгээний ээлжийн тоог нэмэгдүүлж, цулгуй уриншийн хэмжээг бууруулан хөрсний үржил шимд ээлтэй таримал тариалах, ногоон бордуурт уриншийг хийж хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах, үржил шимийг дээшлүүлэх дэвшилтэт технологи нэвтрүүлэн техникийн шинэчлэл, боловсон хүчний чадавхийг сайжруулна..

**Зорилт 7: Бүх үе шатанд (2017-2024):** Байгаль орчинд халгүй аргаар ургамал хамгаалах болон хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх арга хэмжээг авна.

**Зорилт 8:** Жимс, жимсгэний нэр төрлийг олшруулан тариалах талбайг нэмэгдүүлж, хүн амын хүнсэн дэх жимс жимсгэний хэрэглээ, хангамжийг нэмэгдүүлнэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

-Жимс жимсгэнэ тарьсан талбайг 787 га-д хүргэж, 180 тонн ургац хураан авах.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Жимс жимсгэнэ тарьсан талбайг 847 га-д хүргэж, 230 тонн ургац хураан авах.

**Зорилт 9:** Малын тэжээл үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/**

-Малын тэжээлийн ургамал тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлж, үр тариа тариалахад тохиромжгүй бүс нутагт тэжээлийн ургамал тариалах.

- Ашиглалтгүй байгаа талбайг судалж, тэжээлийн болон олон наст ургамал тарих.

-Туул, Хэрлэн голын сав газарт олон наст ургамал тарих талбайг сонгох, тариалах.

- Малын тэжээлийн тариалалтыг 9500 га-д хүргэх.

-Тэжээлийн үйлдвэр, цехүүдийн суурилагдсан хүчин чадлыг бүрэн ашиглах

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Тэжээлийн ургамлын нэр төрлийг нэмэгдүүлж, тэжээлийн үйлдвэр шинээр байгуулах замаар тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх,

-Малын тэжээлийн тариалалтыг 12000 га-д хүргэх.

### **1.3.Аж үйлдвэр, үйлчилгээ, аялал жуулчлалын салбар**

**ЗОРИЛГО 1:** “Аймгийн инновацийн дунд хугацааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж, аж үйлдвэрийг дэвшилтэт технологи, инновацид суурилан хөгжүүлж, үр ашигтай бүтээмжтэй тогтолцоог бүрдүүлж, эдийн засаг, нийгэмд оруулах хувь хэмжээг дээшлүүлнэ.

**Зорилт 1: Бүх үе шатанд /2017-2024 он/:** Төрийн захиргааны төв байгууллагууд-Нутгийн удирдлага-шинжлэх ухаан-бизнесийн байгууллагуудын түншлэлийг сайжруулж, “Шинжлэх ухааны парк”-ийг Төв аймгийн Зуунмод хотын бүс нутагт байгуулахад хамтран ажиллана.

**Зорилт 2:** Аймгийн харьяат эрдэмтэн судлаачидтай хамтран эдийн засаг, нийгмийн салбарт захиалгат судалгаа, шинжилгээний ажлуудыг гүйцэтгүүлэн, нутгийн удирдлага, үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

- Аймгийн эрдэмтэн судлаачдын зөвлөлийг байгуулж, түүний залгамж халааг бэлтгэн сургаж, “Аймгийн орон тооны бус судалгаа шинжилгээний мэргэжлийн баг” ажиллуулж, судалгааны ажлуудыг эхлүүлэх.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-“Аймгийн орон тооны бус судалгаа шинжилгээний мэргэжлийн баг”-аар захиалгат судалгааны ажлууд гүйцэтгүүлэн, шинэ санаа, шинэлэг бүтээлийг үйлдвэр, үйлчилгээнд нэвтрүүлж хэвших ба шинжлэх ухааны паркийн үйл ажиллагааны үр өгөөжийг аймаг орон нутагт хүртэх боломжийг бүрдүүлэх.

**ЗОРИЛГО 2:** Аймгийн орон зай бүсчилсэн хөгжлийн судалгаа, орон нутгийн түүхий эдийн нөөц, байгалийн баялаг, Улаанбаатар хотын хөгжлийн төлөвт тулгуурлан боловсруулах салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлж, ДНБ-д боловсруулах салбарын үйлдвэрийн эзлэх хувийн жинг 20-аас доошгүй хувьд хүргэнэ.

**Зорилт 1:** Үйлдвэржилт 21:100 хөтөлбөрийн хүрээнд “Цардуулын үйлдвэр”, “Арьс шир гүн боловсруулах үйлдвэр”, “Адууны дэл сүүл, эхэсийн үйлдвэр” байгуулж, экспортыг орлох бүтээгдэхүүнээр дотоодын болон бүс нутгийн хэрэгцээг хангана.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

- “Цардуулын үйлдвэр”- ийг байгуулах судалгаа, шинжилгээг хийлгэж, дүгнэлт гаргуулан, хөрөнгийн асуудлыг шийдвэрлэн ажлыг эхлүүлэх.

- Итали улстай хамтран “Арьс шир гүн боловсруулах үйлдвэр”, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар “Адууны дэл сүүл, эхэсийн үйлдвэр” байгуулах.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

- “Цардуулын үйлдвэр”-ийг ашиглалтанд оруулж, үйл ажиллагааг жигдрүүлэх.

- Өндөр болон дэвшилтэт технологи, инновацид суурилсан экспортын чиг баримжаатай боловсруулах үйлдвэрлэлийг кластераар хөгжүүлж, экспортод гаргах бүтээгдэхүүний хэмжээг нэмэгдүүлэх.

**Зорилт 2:** Орон нутгийн түүхий эдийн нөөцөд тулгуурласан, байгаль орчинд ээлтэй, боловсруулах чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжсэн ЖДҮ-27 төслийг хэрэгжүүлнэ.

**Нэгдүгээр үе шат: (2017-2020):**

- Бүх сумдад бага оврын, сүү төвлөрүүлэх газар, сүү боловсруулах, сүү хатаах үйлдвэр, мал нядалгааны газар, мах, ногоо, жимс, боловсруулах үйлдвэр байгуулах.

- “Мал эрүүлжүүлэх, бордох, нядлах, боловсруулах, экспортлох үндэсний парк” байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх.

- Бүх сумдад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг бэлтгэх, анхан шатны чанарын тордолт хийх нэгжүүдийг байгуулах.

- Малын арьс шир, ноос ноолуур зэрэг түүхий эдийг байгаль орчинд сөрөг нөлөөгүй шинэ дэвшилтэт техник технологиор боловсруулж, гутал, дээл, нэхий эдлэл, эсгий, сүжмэл бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөнгөн үйлдвэрийн салбарын жижиг дунд үйлдвэр байгуулахыг дэмжих.

- Орчин үеийн техник технологитой, олон улсын стандарт шаардлагад нийцсэн арьс шир боловсруулах үйлдвэрийг байгуулах асуудлыг гадаадын хөрөнгө оруулагчтай хамтран шийдвэрлэх

- Ойн хаягдал, нөөцөд тулгуурласан шахмал модон эдлэл, хавтангийн үйлдвэр, мод боловсруулах үйлдвэр байгуулах.

- Сум бүрийг өөрийн гэсэн 2-оос доошгүй нэрийн бүтээгдэхүүнтэй болгож, борлуулалтыг дэмжсэн, үйл ажиллагааг сурталчилсан Үзэсгэлэн худалдааны давтамжийг нэмэгдүүлэх.

- ХАА-н үйлдвэрлэл, технологийн парк байгуулах асуудлыг судалж хэрэгжүүлэх.

**Хоёрдугаар үе шат: (2021-2024):**

- Сум бүрийг орчин үеийн техник, технологи бүхий тогтмол үйл ажиллагаатай үйлдвэр, цехтэй болгож, үйлдвэрлэлийг хөгжүүлэн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэн, өөрийн аймаг, бүс, нийслэл, олон улсын нисэх онгоцны буудлын хэрэгцээг хангаж, гадаад зах зээлд нийлүүлэх ажлыг эхлүүлэх.

**Зорилт 3:** Аймгийн худалдаа, үйлчилгээний салбарын үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

- Орон нутгийн бизнес эрхлэгчид, үйлчилгээний байгууллагуудыг дэмжин өргөжүүлж, зарим сумдад стандарт хангасан хүнс барааны зах, супермаркет, зоогийн газар, зочид буудал, ахуйн үйлчилгээ байгуулах үйл ажиллагааг дэмжих.



### **Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

- Худалдааны захиалгат үйлчилгээг бий болгож зөв сонголт, соёлтой хэрэглээг хэвшүүлэх

- Өргөн сонголт бүхий нийтийн хоолны болон зочид буудлууд, ахуйн үйлчилгээний төвүүдийг бий болгож соёлтой үйлчилгээг нэвтрүүлэх

- Худалдааны захиалгат үйлчилгээ нэвтрүүлэх.

**Зорилт 4: Бүх үе шатанд /2017-2024/:** Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн кластер, барилгын материалын үйлдвэрлэлийн кластер, аялал жуулчлалын кластер /сүлжээ/-ыг бүсчлэн хөгжүүлнэ.

- Аймгийн Зүүн бүсэд байгалийн баялаг өвөрмөц тогтоц бүхий түүх соёлын дурсгалт газар, нутгийн иргэдийг түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, Чингис хааны онгон “Хаадын цогцолбор” байгуулах

-Барилгын материалын үйлдвэр, сүү, сүүн бүтээгдэхүүний кластер /хуурай сүүний үйлдвэр/ хөгжүүлнэ.

- Аймгийн Төвийн бүсэд Евро ази аялал жуулчлал, Манзушир шашин, соёлын үндэсний цогцолбор, Олон улсын худалдаа, үйлчилгээний төв, олон улсын зэрэглэлийн зочид буудал байгуулах.

- Ноос, ноолууран бүтээгдэхүүний кластер хөгжүүлэх.

- Аймгийн Баруун бүсэд уламжлалт мал аж ахуйд түшиглэсэн мах, арьс шир боловсруулах үйлдвэр байгуулах.

- Аймгийн Хойд бүсэд эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх бодлого баримтлан мах, сүү, газар тариалангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн кластерыг хөгжүүлж эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн дотоодын хэрэгцээг хангахын зэрэгцээ экспортод гаргах.

**Зорилт 5. Бүх үе шатанд /2017-2024/** Олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах ажилд орон нутгийн оролцоог хангаж, аймгийн иргэдийг ажлын байраар хангах, чөлөөт бүсд аймгийн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа явуулах нөхцөл бололцоог бүрдүүлнэ.

**Зорилт 6:** Нутгийн иргэдэд түшиглэсэн үндэсний түүх соёл, уламжлал, зан заншил, унаган байгаль, нүүдэлчин ахуй, аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлнэ.

#### **Бүх үе шатанд (2017-2024 он)**

- Аялал жуулчлалыг хөгжүүлэх аймгийн хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж, аялал жуулчлалын цогцолбор байгуулах асуудлыг гадаад дотоодын хөрөнгө оруулагчдыг татах замаар шийдвэрлэх.

- Орон нутгийн иргэд, нүүдэлчин ахуйд түшиглэсэн эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

- Эрүүл мэндэд ашиг тустай рашаан ус түшиглэсэн эрүүл мэндийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

- Зуунмод голын орчны бүсийг амралт чөлөөт цагийн бүс болгон тохижуулна.

- Олон улсын стандартад нийцсэн морин тойруулга байгуулах боломжийг судалж хэрэгжүүлнэ.

- Аялал жуулчлалын бүс нутгуудад жишиг жуулчны баазуудыг байгуулах

#### **1.4.Дэд бүтцийн салбар**

**ЗОРИЛГО 1:** Ногоон хөгжлийн чиг баримжаанд тулгуурлан хот байгуулалтын томоохон инженерийн дэд бүтцийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэн, эдийн засгийн

өсөлтийг хангах, зам тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлэн, иргэдийн ая тухтай амьдрах тохилог орчныг бүрдүүлнэ.

**Зорилт 1:** Сумын төв, суурин газруудыг ногоон хөгжлийн стандарт, загварт нийцүүлэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлж, иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

-Бүх сумын төвийг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй болгон хөгжүүлэх.

-“Шинэ сум”, “Эко тохилог хашаа”, “Тохилог зуслангийн хороолол” төслүүдийг хэрэгжүүлж, сум суурин газруудын нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, хүүхдийн спорт, тоглоомын талбайг тохижуулах.

-Төв суурингийн гэр хорооллын айл өрхүүдийг төвлөрсөн халаалтын системд холбох асуудлыг ээлж дараатай шийдвэрлэх.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Ерөнхий төлөвлөгөөний дагуу сумын дэд бүтэц, төвийн гудамж, талбай, авто зам, тохижилт, ногоон байгууламж, үйлдвэрлэл, үйлчилгээ, орон сууцны хотхонг төлөвлөн төр хувийн хэвшлийн оролцоотой бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэж, ашиглалтанд оруулах.

-Зуунмод хотын инженерийн хангамжийн шугам сүлжээний техникийн шийдлийг хонгилын системээр шийдвэрлэх.

-Төв суурингийн гэр хорооллын айл өрхүүдийг төвлөрсөн халаалтын системд бүрэн холбох.

**Зорилт 2:** Олон улсын нисэх буудлын шинэ суурьшлын бүс, тээвэр ложистикийн төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг бүсийн тулгуур төв Зуунмод хотын хөгжилтэй уялдуулан боловсруулж, зам харилцаа, инженерийн дэд бүтэц, барилга байгууламжийг үе шаттайгаар байгуулан орчин үеийн “Smart green city” буюу “Ухаалаг ногоон хот” болгон хөгжүүлнэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

-Олон улсын нисэх буудлын шинээр бий болох суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөө, Тээвэр ложистикийн төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад аймгийн оролцоог ханган, бүтээн байгуулалтад оролцох.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Төлөвлөлтийн хүрээнд зам харилцаа, инженерийн дэд бүтцийг үе шаттайгаар байгуулж, бүтээн байгуулалтын төслүүдийн барилга байгууламжуудыг ашиглалтанд оруулах.

**Зорилт 3:** Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хот байгуулалт, ногоон хөгжлийн стандарт, загварт нийцсэн дэд бүтэц бүхий орон сууцны хангамжийг нэмэгдүүлж, дахин төлөвлөлт хийх, барилгын дулаан алдалтыг бууруулах арга хэмжээ авна.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

-“Манзушир өргөө-1000 айлын орон сууцны хороолол”-ыг үргэлжлүүлэн байгуулж дуусган, Зуунмод хотын шинэ төвийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу дэд бүтэц, шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэх.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Зуунмод хотод 19,6 га газарт 2-р ээлжийн орон сууцны хороолол барих ажлыг эхлүүлэх.

**Зорилт 4:** Эрүүл ахуйн шаардлага хангахгүй болсон хуучин орон сууцны барилгуудыг дахин төлөвлөлтөнд хамруулж, шинэчлэх ажлыг зохион байгуулна.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

- Зуунмод хотын хүнсний үйлдвэрийн байрнуудын орчим, 1, 2, 34, 35, 36-р байрнуудын дахин төлөвлөлтийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулж, дэд бүтэц, шугам сүлжээ, барилга байгууламж байгуулах.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

- Зуунмод хотын бусад хуучин орон сууц, гэр хорооллын зарим байршлуудад дахин төлөвлөлтийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулж, дэд бүтэц, шугам сүлжээ, барилга байгууламжийг байгуулах.

**Зорилт 5:** Хүн амын өсөлт, орон сууцны хэрэгцээтэй уялдуулан аймгийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

- “Түрээсийн орон сууц” хөтөлбөр, “Хямд өртөгтэй орон сууц” үндэсний хөтөлбөр, “Амины орон сууц” төсөл, “Хямд өртөгтэй орон сууц” төслүүдийг гадаад, дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж, аймгийн хэмжээний орон сууцны хангамжийг 11 хувьд, Зуумод хотын хэмжээнд 45 хувьд хүргэх.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

- Аймгийн хэмжээний орон сууцны хангамжийг 20 хувьд, Зуунмод хотын хэмжээнд 70 хувьд хүргэх.

**Зорилт 6:** Төсөвт байгууллагуудын барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, их засвар хийх ажлуудыг гадаадын зээл тусламж, төсөл, улсын болон орон нутаг, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлнэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

- Эрэмбэ дарааллын дагуу 15-аас доошгүй барилга байгууламжийг шинээр барьж, 30-аас доошгүй барилга байгууламжийн их засварт 30.0 тэрбум төгрөгөөс доошгүй хөрөнгө оруулалтын ажлыг хийж гүйцэтгэх.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

- Эрэмбэ дарааллын дагуу 30 барилга байгууламжийг шинээр барьж, 76 барилга байгууламжийн их засварт 60.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг хэрэгжүүлэх.

**ЗОРИЛГО 2:** Аймгийн газрын талаар баримтлах нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулан, газар өмчлөлийг хуулийн дагуу зохион байгуулж, эдийн засгийн эргэлтэнд оруулах боломж, нөхцлийг бүрдүүлнэ.

**Зорилт 1:** Газрын талаар баримтлах аймгийн нэгдсэн бодлогыг боловсронгуй болгож, нэн тэргүүнд аймгийн иргэд, аж ахуйн нэгжүүдэд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх бодлого баримтлана.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

- Газрын талаар баримтлах аймгийн нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх.

-Газар өмчлөөгүй аймгийн иргэн бүрт өмчлүүлэхэд шаардлагатай газрын хэмжээг тодорхойлж, байршлыг тогтоон төлөвлөлт хийж газар өмчлөлийг хуулийн хүрээнд зохион байгуулж, аймгийн нийт иргэдэд /100 хувьд/ газар өмчлүүлэх.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Өмчлөгдсөн газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах боломжийг бүрдүүлэх.

**Зорилт 2:** Газрын нөөцийн ашиглалт хамгаалалтыг сайжруулж, тариалангийн болон бэлчээрийн газруудын зүй зохистой ашиглалтыг нэмэгдүүлнэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

-Газар ашиглалтын төлөв байдалд үнэлгээ өгч шаардлагатай арга хэмжээ авах, тариалангийн талбайн үржил шимийг дээшлүүлж, тариалан эрхлэгчдэд газрыг урт хугацаагаар эзэмшүүлэх, түрээслүүлэх /өмчлүүлэх/ зэргээр хөрсний эвдрэлийг бууруулах зохион байгуулалтын цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх, бэлчээрийг зохистой, хуваартай ашиглах, стандартын холбогдолтой мэдээ мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх оновчтой тогтолцоог бий болгох.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Газрыг оновчтой, зохистой ашиглах, бэлчээрийн даац хэтрэлтийг бууруулах, тариалангийн талбайн хөрсний эвдрэлийг багасгаж, үржил шимийг нь нэмэгдүүлэхэд шинжлэх ухааны ололт, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх.

**ЗОРИЛГО 3:** Эрчим хүчний менежментийг боловсронгуй болгож, байгаль орчинд халгүй тэргүүний техник, технологи нэвтрүүлж, үйлдвэрлэл, хэрэглээний үр ашгийг дээшлүүлнэ.

**Зорилт 1:** Аймаг, сумдын төвийн хүн амын ундны цэвэр усны найдвартай эх үүсвэрийг хангана.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

- Зуунмод сумын усны ашиглах боломжтой нөөцийг шинэчлэн тогтоолгож, сумдын ундны усны эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоож, орон нутгийн тусгай хэрэгцээнд бүрэн авч, усан хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээний/2x2000м<sup>3</sup>/хоног/ болон усан сангийн өргөтгөл шинэчлэлтийн ажлыг эхлүүлэх.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Шинэчлэлтийн ажлыг бүрэн хийж гүйцэтгэн, ашиглалтад оруулах.

**Зорилт 2:** Төвлөрсөн халаалтын системд холбогдох боломжтой сумын төвүүдийг төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг төр, хувийн хэвшлийн оролцоотой үргэлжлүүлэн хийж дуусгаж, зарим сумын төвүүдийг цэвэр усны төвлөрсөн шугам сүлжээ, ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжтай болгоно.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

-Сумдыг төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг гадаад, дотоодын хувийн хөрөнгө оруулалт татах замаар хэрэгжүүлж төвлөрсөн халаалтын нэгдсэн системд бүрэн холбогдсон сумын тоог 20-д хүргэх.

-Зарим сумын төвүүдийг цэвэр усны төвлөрсөн шугам сүлжээ, ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжтай болгох.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

- Цэвэр усны нэгдсэн шугам сүлжээ, ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээнд 10 сумыг холбосон байх.

**Зорилт 3:** Эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээг нэмэгдүүлж, эрчим хүчний шинэ эх үүсвэр, болон сэргээгдэх эрчим хүчний байгууламжийг барьж байгуулах ажлыг дэмжинэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

- Аймгийн хэмжээнд нар, салхины эрчим хүч ашиглах боломжийн талаарх судалгааг эрдэм шинжилгээ, мэргэжлийн байгууллагаар хийлгэх.

-Зуунмод хотод Дулаан, цахилгааны станц байгуулж, ашиглалтанд оруулна.

-Төв суурин газруудын цахилгаан эрчим хүчний дэд станцуудыг өргөтгөн, дамжуулах шугамыг шинэчлэн, шинээр үүссэн сууршлын бүсийн айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр хангах.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Шинэ сууршлын бүсийн айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр бүрэн хангах.

**Зорилт 4:** Байгаль орчинд сөрөг нөлөө багатай сэргээгдэх эрчим хүчний технологийг дэмжин хөгжүүлж, эрчим хүчний үйлдвэрлэлд түүний эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлнэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

-Олон улсын нисэх буудлыг түшиглэн 25 мВт хүчин чадалтай нарны цахилгаан станц, Зуунмод суманд 9мВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станцыг шинээр байгуулж, үйлдвэрийг ашиглалтанд оруулах.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Сумын эмнэлэг, сургууль, нийтийн үйлчилгээний газрууд болон цаашид баригдах барилга байгууламжийг сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр хангах, худгаас ус татах болон газар тариаланг усжуулахад нар, салхины эрчим хүчийг өргөн ашиглах.

**Зорилт 5:** Төвлөрсөн шугам сүлжээнээс алслагдсан айл өрх, албан байгууллага, барилга байгууламжуудыг ашиглалтын зардал багатай шинэ технологийн утаа бага ялгаруулдаг цахилгаан халаалт, сэргээгдэх эрчим хүчээр хангана.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

-Шинэ технологийн ашиглалтын зардал багатай, утаа бага ялгаруулах цахилгаан халаалт, сэргээгдэх эрчим хүчээр хангах боломжийг судлаж, нэвтрүүлж эхлэх.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Алслагдсан айл өрх, албан байгууллага, барилга байгууламжуудыг ашиглалтын зардал багатай шинэ технологийн утаа бага ялгаруулдаг цахилгаан халаалт, сэргээгдэх эрчим хүчээр бүрэн хангах.

**ЗОРИЛГО 4:** Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр ложистикийн сүлжээг хөгжүүлнэ.

**Зорилт 1:** Хөшгийн хөндийн олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэсэн ложистикийн төв, Богд хаан төмөр замын бүтээн байгуулалт болон, дамжин өнгөрөх зам тээврийн сүлжээг дагасан аймгийн иргэдийн суурьшлын бүс хот, хотожсон суурингууд байгуулах үүсгэл санаачилгыг дэмжиж ажиллах.

**Бүх үе шатанд: /2021-2024 он/:**

-Олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэсэн орон нутгийн тээвэр зуучлалын төв байгуулах, Богд хаан төмөр замыг барьж байгуулах, ашиглалтад оруулах бүх үе шатанд орон нутгийн оролцоог хангах.

**Зорилт 2: Бүх үе шатанд /2017-2024 он/:** Алтанбулаг, Замын-үүд чиглэлийн олон улсын хурдны зам байгуулах ажилд орон нутгийн оролцоог ханган, зам дагасан бизнесийн орчинд орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжийг хамруулна.

**Зорилт 3:** Авто замын сүлжээг өргөтгөн сайжруулж, орон нутгийн чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг нэмэгдүүлнэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

- Зуунмод хотод гудамж төслийг хэрэгжүүлэн 4.6 км автозамын ажлыг эхлүүлэх,  
-Манзушир чиглэлийн автозамыг ашиглалтад оруулах.  
- Хэвтээ болон босоо тэнхлэгийн автозамуудтай ойролцоох 8 сумын 192 км замыг хатуу хучилттай автозамаар холбох ажлыг эхлүүлэх.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Гудамж төслийг бүрэн хэрэгжүүлж дуусах.

-Алтанбулаг, Эрдэнэсант, Угтаалцайдам, Цээл, Заамар, Аргалант, Сүмбэр, Сэргэлэн, Баяндэлгэр сумын 192 км замыг хатуу хучилттай автозамыг ашиглалтад оруулах.

-Шинэ нисэх онгоцны буудал-Зуунмод хот чиглэлийн хатуу хучилттай замыг барьж ашиглалтад оруулах.

**Зорилт 4:** Хэрэглэгч, зорчигчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай тээврийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлнэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

-Нийтийн зорчигч тээвэр, шуудан тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан бүх сумдын зорчигч тээврийн үйлчилгээг стандартын шаардлага хангасан аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлж, иргэдийн ая тухтай аюулгүй зорчих нөхцлийг бүрдүүлэх.

-Зуунмод хотын төвд Зорчигч тээврийн үйлчилгээний төв, техникийн үзлэгийн төв шинээр барьж ашиглалтанд оруулах.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Зорчигч, болон ачаа тээврийн үйлчилгээнд орчин үеийн ухаалаг системд бүрэн нэвтрүүлэх.

-Алтанбулаг, Замын-үүд чиглэлийн олон улсын хурдны замын дагуу зорчигчдод үйлчлэх үйлчилгээний төв, авто үйлчилгээний төв, ачаа ачиж буулгах орон нутгийн ложистикийн төвүүдийг шинээр байгуулах.

-Олон улсын зорчигч болон ачаа тээврийн онгоц хүлээн авах нөхцлийг бүрдүүлэн шууд харилцаат Япон улсын Тоттори муж, БНСУ-ын Ганвон муж зэрэгтэй агаарын замын шугам нээх асуудлыг шийдвэрлүүлэх.

**Зорилт 5:** Мэдээлэл, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, шинэ техник, технологийг нэвтрүүлж, “Ухаалаг-Төв” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

-Аймгийн хэмжээнд “Ухаалаг-Төв” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэн бүх сумдыг WiFi-тай холбох.

-Өндөр хурдны шилэн кабельд холбогдоогүй Баян-Өнжүүл, Баянжаргалан, Борнуур сумдыг шилэн кабельд холбох.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Интернетийн хурдыг олон улсын стандартын түвшинд хүргэх.

## **2. НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**

### **2.1. Эрүүл мэндийн салбар**

**ЗОРИЛГО 1:** Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг иргэдийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, санхүүжилтийг зохистой зарцуулан, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, дундаж наслалтыг уртасгана.

**Зорилт1.** Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх тогтолцоог чанаржуулан, оношилгоо үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгана.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

-Эмнэлгийн тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчилж, урьдчилан сэргийлэх, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлэх, зохих арга хэмжээг

чанартай, хүртээмжтэй зохион байгуулах, тандалт, эрт илрүүлэлтийн тогтолцоо, лавлагаа лабораторийг бэхжүүлж, хүн амын дундаж наслалтыг 74.6-д хүргэх.

-Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг нэвтрүүлэн, аймгийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэх дунд хугацааны баримт бичгийг 2017-2020 онд батлан хэрэгжүүлж, үр нөлөөг үнэлэх.

-Нэн шаардлагатай мэргэшлээр эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэх, сумдын эрүүл мэндийн төвүүдийг мэргэжилтнээр хангахад хүний нөөцийг төлөвлөх, сургах, мэргэшүүлэх, урамшуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлэх.

-Нүүдлийн амбулаторийн үзлэг, оношилгоог сумдад хүргэх ажлыг эрчимжүүлэх замаар 30,000 иргэнийг урьдчилан сэргийлэх үзлэгт үнэ төлбөргүй хамруулж, мэдээллийн сан бүрдүүлж, үр дүнг тооцох.

- “Элэг бүтэн Төв аймагчууд” хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлэн, хэрэгжилтийг 90%-д хүргэж, элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшинг 10.000 хүн амд 4.72 промилль болгож бууруулах.

-Эмийн чанар, аюулгүй байдалд тандалт, судалгаа хийх тогтолцоог сайжруулах замаар антибиотикт нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх, хянах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх.

- Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаанд MNS 5095:2013, MNS 5081:2013, MNS 5292:2011 стандартуудыг тус тус нэвтрүүлэн, үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах.

- “Үйлчлүүлэгч төвтэй” тусламж, үйлчилгээний төрөл, гүйцэтгэлтэй уялдсан олон улсын чанарын удирдлагын тогтолцоо (ISO 9001:2008)-г аймгийн Нэгдсэн эмнэлэгт хэрэгжүүлэх.

#### **Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг эмчилгээ, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлж, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлж, иргэн бүрийг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд бүрэн хамруулж, зарим сумдыг хамарсан алсын зайн оношилгооны сүлжээг бий болгож, өвчлөл, нас баралтын эрсдэлт хүчин зүйлийг бууруулж, хүн амын дундаж наслалтыг 76,6-д хүргэх.

- Нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн үйл ажиллагаанд MNS 5095:2013, MNS 5081:2013, MNS 5292:2011 стандартыг мөрдүүлэн, үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх.

-Анхан болон лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний чанарыг эрс сайжруулж, нотолгоонд суурилсан эмнэлгийн тусламжийг цаг алдалгүй үзүүлэн, Нэгдсэн эмнэлгийн хүчин чадлыг Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн зэрэглэлд ойртуулж, төрөх, хүүхэд, гэмтэл, мэс заслын тусламж, үйлчилгээг өргөжүүлэх.

- “Элэг бүтэн төв аймагчууд” хөтөлбөрийн хэрэгжилтийг тогтвортой хангах замаар элэгний хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшинг 10.000 хүн амд 4.32 промилль болгож бууруулах.

-Уламжлалт, сэргээн засах, хөнгөвчлөх, сувилахуйн тусламж, үйлчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, олон улсын жишигт хүргэх.

-Орчин үеийн шинжлэх ухааны дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэх, өндөр хөгжилтэй орны эмч, эмнэлгийн мэргэжилтнийг багаар нь урьж ажиллуулах, өндөр хөгжилтэй оронд эмч, мэргэжилтнийг сургаж чадавхижуулах замаар өндөр технологи, ур чадвар шаардсан тусламж, үйлчилгээг аймагтаа үзүүлдэг болох.

**Зорилт 2.** Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдлыг тогтвортой бууруулах.

#### **Нэгдүгээр үе шат /2017-2020/:**

-Эх барихуйн шалтгаант эхийн эндэгдлийн түвшинг 100.000 амьд төрөлтөд 0, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 15, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 13 болгож бууруулах.

#### **Хоёрдугаар үе шат /2021-2024/:**

-Эх барихуйн шалтгаант эхийн эндэгдлийн түвшинг 100.000 амьд төрөлтөд 0, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 12, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 11 болгож бууруулах.

**Зорилт 3.** Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.

#### **Нэгдүгээр үе шат /2017-2020/:**

-Хүн амын хорт дадал, зуршлыг бууруулж, 10000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 17.4 промилль, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 10.5 промилль хүртэл бууруулах.

-Хүн амд, ялангуяа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагсад эрүүл мэндийн мэдлэг олгох, ухуулга нөлөөлөл, мэдээлэл сурталчилгаа хийж, үндэсний ёс заншилд тулгуурласан уламжлалт анагаах ухааны аргуудыг ашиглан урьдчилан сэргийлэх, эрүүл зан үйл, аж төрөх хэв маягийг төлөвшүүлэх.

-Хот суурин, уул уурхайн бүс нутгийн агаар, хөрс, усны бохирдол түүний шалтгаан, үр дагаврыг тандах, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийг бууруулах, арилгах цогц арга хэмжээг хэрэгжүүлэх.

#### **Хоёрдугаар үе шат /2021-2024/:**

-Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, 10000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 16 промилль, хорт хавдраас шалтгаалсан нас баралтыг 9 промилль хүртэл бууруулах.

-Иргэн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхитэй оролцоонд тулгуурлан хүн амын өвчлөл, нас баралтын шалтгаан, үр дагаврыг судлах, эрт сэрэмжлүүлэх, нас насанд нь тохирсон өвчний эрт илрүүлэг, хяналтын тогтолцоог бүрдүүлэх

**Зорилт 4.** Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхийг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакцинийг хүн бүрт хүртээмжтэй болгож, зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг бууруулна.

#### **Нэгдүгээр үе шат /2017-2020/:**

-Товлолт дархлаажуулалтын хамралтын хувийг 98.5, 10000 хүн амд вируст гепатитын өвчлөлийг 3, сүрьеэгийн тохиолдлыг 14.4 болгон бууруулах.

-Аймгийн Нэгдсэн эмнэлгийн түвшинд сүрьеэгийн оношилгооны чадавхийг нэмэгдүүлж, дижитал рентген аппарат, оношлуур, суурин болон явуулын дезкамертай болж, ариутгал халдваргүйтгэлийг өндөр түвшинд хийх.

-Зооноз халдварт өвчний сэргийлэлтийн төв байгуулж, гэнэтийн аюул, байгалийн гамшиг, нийтийг хамарсан халдварт өвчний дэгдэлт гэх мэт нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээ авах чадавхийг бүрдүүлэх

#### **Хоёрдугаар үе шат /2021-2024/:**

-Товлолт дархлаажуулалтын хамралтын хувийг 99, 10000 хүн амд вируст гепатитын өвчлөлийг 2.5, сүрьеэгийн тохиолдлыг 14 болгон бууруулах.

-Шинэ болон дахин сэргэн тархаж байгаа халдварт өвчнийг уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны хүчин зүйлтэй /биохэмнэл/ уялдуулан судлах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтын үйл ажиллагааг өргөжүүлэх.

## **2.2. Боловсрол, соёл, урлагын салбар**



**ЗОРИЛГО 2:** Бүх шатны боловсрол, сургалтын байгууллагыг хүний хөгжлийн төв болгон хөгжүүлж, эрүүл аюулгүй, ээлтэй орчин, чанартай, хүртээмжтэй үйлчилгээ бий болгоно.

**Зорилт 1:** Боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд бүрт чанартай боловсролыг тэгш оролцоотой хүргэнэ.

**Нэгдүгээр үе шат (2017-2020 он):**

-Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хамран сургалтыг сумдын хувьд 87.3 хувьд хүргэж, хүүхэд бүрийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжих нөхцөлийг бүрдүүлэх

-Суурь боловсролын хамрагдалтыг 87%-д хүргэж, бүрэн дунд боловсролд сонголттой, уян хатан хөтөлбөрийг нэвтрүүлэх

-Боловсролын салбарын хүний нөөцийн төлөвлөлт, бодлогод тулгуурлан удирдах ажилтан, багш нарыг сургаж бэлтгэх, дадлагажуулах, сэлгэх, туршлага харилцан солилцох, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, мэргэжлийн багшийн хангалтыг 100 хувьд хүргэх..

-Боловсролын үйлчилгээг уламжлалт зан заншил, өв соёл, эх түүх, амьдрах ухаан болон шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэхэд чиглүүлэх.

-Боловсролын байгууллагын орчинд суралцагчийг эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн сөрөг үзэгдлээс хамгаалах нөхцөл, боломжийг бүрдүүлэх.

-Боловсролын байгууллагын бүтэц, хэв шинж зохион байгуулалт, менежментийг сайжруулж, зарим ерөнхий боловсролын сургуулийг төрөлжүүлэн хөгжүүлэх.

-Насан туршийн боловсролын төв, нэгж байгууллагын сургалтын орчин нөхцлийг сайжруулж, иргэд бие даан боловсрол эзэмших, насан туршид суралцах нөхцөлийг бүрдүүлэх.

-Монгол улсын БСШУСЯам болон Монгол банкнаас хэрэгжүүлж байгаа Хувь хүний санхүүгийн суурь боловсролыг төлөвшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

**Хоёрдугаар үе шат (2021-2024 он):**

-Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хамран сургалтыг 92 хувьд хүргэж, хүүхэд бүрийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжих нөхцөлийг бүрдүүлэх.

- Боловсролын салбарын хүний нөөцийн төлөвлөлт, бодлогод тулгуурлан удирдах ажилтан, багш нарыг сургаж бэлтгэх, дадлагажуулах, сэлгэх, туршлага харилцан солилцох, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, мэргэжлийн багшаар бүрэн хангаж, магистр багшийн эзлэх хувийг 75-д хүргэн, багшийг чадавхжуулах.

-Боловсролын үйлчилгээг уламжлалт зан заншил, өв соёл, эх түүх, амьдрах ухаан болон шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэхэд чиглүүлж, боловсролын олон улсын чанарын үнэлгээнд /PISA/ хамрагдах.

- Суурь боловсролын хамрагдалтыг 92%-д хүргэж, бүрэн дунд боловсролыг сонголттой, уян хатан хөтөлбөр бүхий мэргэжлийн чиг баримжаа эзэмшүүлэхэд чиглүүлэх.

-Боловсролын байгууллагын бүтэц, хэв шинж зохион байгуулалт, менежментийг сайжруулж, их, дээд сургуулийн салбар сургуультай болох.

-Иргэн бүрд насан туршдаа боловсрол эзэмших орчин, нөхцөл, боломжийг бүрдүүлэн, тэдний хэрэгцээ сонирхолд нийцүүлж мэргэжил, чадвараа дээшлүүлэх сургалтын төрөл, хэлбэрийг дэмжин хөгжүүлэх.

**ЗОРИЛГО 3:** Соёл, урлагийн байгууллагын материаллаг бааз, мэргэжлийн боловсон хүчний хангалтыг сайжруулж, үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлнэ.

**Зорилт 1.** Соёлын салбарт хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

**Нэгдүгээр үе шат (2017-2020 он):**

-Мэргэжлийн урлагийн байгууллагын бүтэц орон тоог нэмэгдүүлж, үндэсний болон сонгодог урлагийг хөгжүүлэх.

**Хоёрдугаар үе шат (2021-2024 он):**

-Сумдын соёлын төвүүдийг “Хүний хөгжлийн төв” болгон хөгжүүлэх.

**Зорилт 2:** Соёлын байгууллагуудын барилга байгууламж, орчин нөхцөл, техник хэрэгсэл материалаг баазыг бэхжүүлнэ.

**Нэгдүгээр үе шат (2017-2020 он):**

- Монгол Туургатан Театрын шинэ байрыг ашиглалтад оруулах.

- Монгол улсын түүх археологи”-ийн музей байгуулахад орон нутгийн оролцоог ханган, ажлыг эхлүүлэх.

**Хоёрдугаар үе шат (2021-2024 он):**

-Олон улсын нисэх онгоцны буудлыг түшиглэн Монголын археологийн музейн орчин үеийн стандартад нийцсэн шинэ барилгыг ашиглалтад оруулж, аялал жуулчлалтай холбон хөгжүүлэх.

**Зорилт 3:** Соёлын өвийн бүртгэл мэдээллийн санг орчин үеийн мэдээллийн сүлжээнд холбох, хадгалалт хамгаалалтыг сайжруулна.

**Нэгдүгээр үе шат (2017-2020 он):**

-Музейг мэдээлэл, мэдлэгийн эх сурвалж болгож, соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах.

**Хоёрдугаар үе шат (2021-2024 он):**

-Нийтийн номын санд цахим мэдээллийн сан бүрдүүлж “Хүний хөгжил-мэдээллийн төв”болгон хөгжүүлэх.

**ЗОРИЛГО 4:** Хүн амыг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх, таатай орчин бүрдүүлж, шилдэг тамирчдыг бэлтгэн гаргана.

**Зорилт 1.** Нийтийн биеийн тамир, чийрэгжилтийг аж төрөх ёсны салшгүй хэсэг, амьдралын чанарыг дээшлүүлэх, чөлөөт цагийн хэрэглүүр болгоход чиглүүлж, энэ чиглэлээр хүмүүжил боловсрол олгох ажлыг чанаржуулна.

**Нэгдүгээр үе шат (2017-2020 он):**

-Иргэдийн бие бялдрын хөгжил соёлыг дээшлүүлэх, биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтээр хичээллэх, заал талбай, тоног төхөөрөмжийн хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх

**Хоёрдугаар үе шат (2021-2024 он):**

-Спортын шинжлэх ухаан, спортын анагаах ухааныг хөгжүүлж эрдэм шинжилгээ, судалгаанд тулгуурлан сургалт дасгалжуулалтыг хөгжүүлэх, бэлтгэлийн түвшинг олон улсын жишигт хүргэх

**2.3. Хүн амын хөгжил, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал**

**ЗОРИЛГО-5.** Иргэдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллыг сайжруулан, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.

**Зорилт 1:** Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээл дэх тэгш оролцоог ханган, мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, иргэдийг хөдөлмөр эрхлэх зөв дадал хэвшилд сургах замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжин байнгын тогтвортой ажлын байрны тоог нэмэгдүүлэн ажилгүйдлийн түвшинг бууруулна.

**Нэгдүгээр үе шат (2017-2020 он):**

-Төр, хувийн хэвшил, ажил олгогчдын түншлэлийг хөгжүүлэх, хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар 6000 шинэ ажлын байр бий болгон, ажилгүйдлийн түвшинг 5.4 хувьд хүргэх.

-Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний MNS6620:2016 стандартыг бүрэн нэвтрүүлж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний нэр төрөл, чанар хүртээмжийг нэмэгдүүлэх замаар 3800-аас доошгүй иргэнийг байнгын ажлын байранд зуучилж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжихнөлөөллийн ажлыг эрчимжүүлж, тогтвортой ажлын байрныг нэмэгдүүлэх.

-Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн мэргэжилтэй ажилтныг бэлтгэн, иргэдийг үйлдвэр дээрх болон мэргэжлийн түр сургалтанд хамруулж, ААНБ-ын түншлэлийг хөгжүүлэх, ажил олгогчийг дэмжих замаар төгсөгчдийг ажлын байраар хангах.

-Өрхийн үйлдвэрлэл, бичил бизнес эрхлэгчдийг зах зээлд өрсөлдөх чадавхитай болгох, ажлын байраа тогтвортой хадгалах, нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор “Бизнес инкубатор төв”-ийг байгуулах.

**Хоёрдугаар үе шат (2021-2024 он):**

-Орчин үеийн дэвшилтэт технологид суурилсан ажлын байрыг дэмжин, мэдлэг ур чадвартай залуу үеийг бэлтгэж, инновацид суурилсан аж ахуй эрхлэлтийг хөнгөлөлттэй зээл, санхүүгийн бодлогоор дэмжих замаар 8000 тогтвортой шинэ ажлын байрыг бий болгон, ажилгүйдлийн түвшинг 4.4 хувьд хүргэх.

-Өндөр технологи, мэдлэгт суурилсан үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд шаардагдах мэргэжилтэй ажилтанг урт, богино хугацаагаар сургаж, мэргэшүүлэн, эдийн засгийн өсөлтөд чухал нөлөө бүхий салбарын хэрэгцээг орон нутгийн ажиллах хүчээр хангах.

-Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэн, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, “Бизнес инкубатор төв”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулан, бойжигчдын 70-аас доошгүй хувь нь ажлын байраа тогтвортой хадгалж, ажлын байрны тоогоо нэмэгдүүлсэн байх.

**Зорилт 2:** Нийгмийн хөгжил хамгааллын цогц үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлж, эрсдэлийг даван туулах чадвар, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар дундаж, дунджаас дээгүүр хэрэглээтэй өрхийн тоог нэмэгдүүлнэ.

**Нэгдүгээр үе шат (2017-2020 он):**

-Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэн, нийгмийн хөгжлийн цогц үйлчилгээ үзүүлж, аймгийн нийт өрхөд дундаж ба дунджаас дээш амьдралын түвшинтэй өрхийн эзлэх хувийг 76,9 хувьд хүргэх.

-Зорилтот өрхийн хөгжил, амьжиргааны талаарх цахим мэдээллийн санг шинэчилж, хэрэглээг нэмэгдүүлэх.

**Хоёрдугаар үе шат (2021-2024 он):**

-Өрх бүрийг хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэн, нийгмийн хөгжлийн цогц үйлчилгээнд хамрагдах өрхийн тоог нэмэгдүүлж, аймгийн нийт өрхөд дундаж ба дунджаас дээш амьдралын түвшинтэй өрхийн эзлэх хувийг 85,5 хувьд хүргэх.

-Зорилтот өрхийн хөгжил, амьжиргааны талаарх цахим мэдээллийн санг баяжуулж, түүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар бусад салбарт мэдээллийг ашиглах.

**ЗОРИЛГО 6:** Иргэдээ эрүүл мэнд, нийгмийн даатгалд бүрэн хамруулах арга хэмжээ авч, ирээдүйд нийгмийн хамгаалалд хамрагдах нөхцлийг бүрдүүлнэ.

**Зорилт 1: Бүх үе шатанд /2017-2024 он/** Эрүүл мэнд, нийгмийн даатгал, сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэн, тэтгэврийн суурь даатгалын тогтолцоонд иргэдийг бүрэн хамруулах замаар өр авлагагүй ажилладаг тогтолцоог бий болгоно.

**ЗОРИЛГО 7:** Хүүхэд, гэр бүл, залуучуудад суурилсан нийгмийн эерэг өөрчлөлтийг бий болгож, тэдэнд ээлтэй орчинг бий болгоно.

**Зорилт 1:** Гэр бүл, хүүхэд, залуучуудад ээлтэй нийгмийн орчныг бүрдүүлж, салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар хүүхдийн эрхийг дээдлэн, гэр бүл, залуучуудын хөгжил, хамгаалал, тогтвортой байдлыг дэмжиж, амьдралын чанарыг сайжруулна.

**Нэгдүгээр үе шат (2017-2020 он):**

-Гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, гэр бүлд зөвлөгөө өгөх MNS6417:2013 стандарт шаардлагыг хангасан жишиг төвийг байгуулах.

-Эрсдэлт нөхцөлд байгаа болон эрх нь зөрчигдсөн хүүхдийг эрэмбэлэх, үйлчилгээний үр дүнг тооцох, хүүхдийн эрсдлийн үнэлгээний программтай болох

-Гэр бүл, хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон, үр дүнтэй өнгөрүүлэх, орчин үеийн техник, тоног төхөөрөмжтэй хүүхдийн парк байгуулах.

**Хоёрдугаар үе шат (2021-2024 он):**

-Хохирогчийг хамгаалах MNS 6040:2009 стандартад нийцсэн жишиг байртай болох.

-Гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлд тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, гэр бүлд зөвлөгөө өгөх MNS 6417:2013 стандарт шаардлагыг хангасан жишиг төвийн үйл ажиллагааг тогтмолжуулах.

-Хүүхдийн зуслангийн MNS5633:2006 стандарт шаардлагыг хангасан зусланг байгуулж, үйл ажиллагааг тогтвортой явуулах

-Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэд рүү чиглэсэн цогц үйлчилгээ үзүүлдэг төвийг байгуулах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сурах орчин нөхцлийг хангах.

**Зорилт 2:** Залуучуудад чанартай хүртээмжтэй боловсрол эзэмшүүлэн, амьдралаа зөв авч явах, хариуцах чадварыг эзэмшүүлж, хөдөлмөрлөх, хөгжих таатай нөхцлийг нь бүрдүүлэн, амьдралын чанарыг дээшлүүлнэ.

**Бүх үе шатанд /2017-2024 он/:**

-Залуучуудын хөгжил, оролцоог дэмжсэн “Залуучуудын оролцоо-Бидний ирээдүй” аймгийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх.

-Залуучуудад амьдралын эрүүл дадал хэв маягийг хэвшүүлэх, эрүүл мэндийн эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх боломжтой аливаа өвчинд өртөхгүй байж улмаар урт удаан, эрүүл саруул амьдрах нөхцөлийг бүрдүүлэх.

-Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, хангалттай цалин хөлстэй хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгож тэднийг амьдралаа авч явах, эдийн засгийн чадавхтай болгоход, бүтээлч сэтгэлгээг нь хөгжүүлэх.

- “Залуучуудын хөгжлийн төвийн үлгэрчилсэн дүрэм”-д нийцсэн “Залуучууд хөгжлийн төв”-тэй болох.

### **3. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ**

**ЗОРИЛГО 1:** Ногоон хөгжлийн үзэл баримтлал, байгаль орчны даац чадамжид суурилж хүний үйл ажиллагаанаас хамааралтай байгалийн доройтлыг хязгаарлан баялгийг нь зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах үйл ажиллагааг, нутгийн иргэд, тэдний үүсгэл санаачилгын болон мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, нийт иргэдэд байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлж, экологийн тэнцвэрт байдлыг хадгалан, ирээдүй хойч үедээ өвлүүлж, үр өгөөжийг нь урт хугацаанд хүртэх боломжоор хангах нөхцлийг бүрдүүлэн ногоон хөгжлийг хангахад оршино.

**Зорилт-1:** Агаар хөрсний бохирдлыг бууруулах, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлж, хүн амыг эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

#### **Нэгдүгээр үе шат (2017-2020 он):**

- Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөгүй, үр ашигтай, дэвшилтэт технологи нэвтрүүлэн, агаарын болон хөрсний бохирдлыг бууруулах.

- Орчны бохирдлыг бууруулах, хэмнэлттэй хэрэглээг бий болгох байгаль хамгаалах уламжлалт ёс заншлаа өвлүүлэх, орчин үеийн амьдралын хэмнэлд нийцсэн, үр ашигтай хэрэглээний соёлыг төлөвшүүлэх.

- Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах боловсруулах үйлдвэр байгуулах.

- Гэр хорооллын айл өрхийн бохирын цооног, задгай нойлын стандартыг хангуулах.

#### **Хоёрдугаар үе шат (2021-2024):**

- Хог хаягдлыг цуглуулан тээвэрлэх, устгах үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлэн боловсонгүй болгон, хог хаягдлын дахин боловсруулах аж үйлдвэрийн парк байгуулах.

- Иргэн бүр хог хаягдлыг ангилан ялгаж, дахин боловсруулах, эдийн засгийн эргэлтэнд оруулах сэтгэлгээ, хандлага төвшиж, эх үүсвэр дээрх хог хаягдлын үнэлэмжийг бий болгох.

**Зорилт-2:** Усны нөөцийг хамгаалах, хуримтлал бий болгох, хомсдол бохирдлоос сэргийлэх, үр ашигтай хэрэглээ, хамгаалалтын цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

#### **Нэгдүгээр үе шат (2017-2020 он)**

- Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглалт, түүний бүрэлдэн тогтох, цэвэр ариун чанараа хадгалах, байгалийн аясаар сэргэх бүхий л боломжийг бүрдүүлэх.

- Хэрэглээний хаягдал /саарал/ усыг цэвэршүүлэн, ногоон байгууламжийн усалгаанд хэрэглэх боломжийг судлан, хэрэгжүүлэх.

- Гол мөрний урсац бүрдэх эхийн, хилийн заагийг тогтоосон газрын 50 хүртэлх хувийг орон нутгийн хамгаалалтад авах.

- Туул голын усны нөөц, чанарт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг арилгах, голын усны цэвэршилтийг хангах, бохирдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх.

#### **Хоёрдугаар үе шат (2021-2024)**

- Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг шинэчлэх.

- Хэрэглээний хаягдал /саарал/ усыг цэвэршүүлэн ахуйн системд хэрэглэх ажлыг сумдад нэвтрүүлэх.

- Гол мөрний урсац бүрдэх эхийн хилийн заагийг тогтоосон газрыг орон нутгийн хамгаалалтанд бүрэн авах.

**Зорилт-3:** Ойг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх чадавхийг дээшлүүлж, ойн талаар улс, орон нутгаас баримтлах бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

**Нэгдүгээр үе шат (2017-2020 он):**

-Ойжуулалт, ойн нөхөн сэргээлтийг эрчимжүүлж, иргэд, хувийн хэвшлийн идэвхи санаачлагыг өрнүүлэн, ойн түймэр, хөнөөлт шавж өвчнөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх, тэмцлийн ажлыг хэрэгжүүлж, ойг хомосдолд хүргэж байгаа хүчин зүйлийн нөлөөг 20%-р бууруулах.

- Аймгийн нутгаас бэлтгэсэн хэрэглээний модны 20-иас доошгүй хувийг сум орон нутгийн мод, модон материалын хэрэгцээнд нийлүүлэх.

**Хоёрдугаар үе шат (2021-2024):**

-Ойжуулалт, ойг нөхөн сэргээлтийг эрчимжүүлэн, ойг хомосдолд хүргэж байгаа хүчин зүйлийн нөлөөг 30%-р бууруулах.

- Аймгийн нутгаас бэлтгэсэн хэрэглээний модны 30 хүртлэх хувийг сум орон нутгийн мод, модон материалын хэрэгцээнд нийлүүлэх.

**Зорилт-4: Бүх үе шатанд /2017-2024 он/ Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох стратеги боловсруулан, хэрэгжүүлж, байгаль орчин, уур амьсгалын мэдээллийн сан байгуулан, орон нутгийн цаг уурын байгууллагын чадавхийг бэхжүүлнэ.**

**Зорилт-5:** Цөлжилт, газрын доройтол, бохирдлыг хязгаарлаж, шинжлэх ухааны үндэслэлтэйгээр нөхөн сэргээх ажлыг хэрэгжүүлнэ.

**Нэгдүгээр үе шат (2017-2020 он)**

-Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг тодорхой бүс нутагт хийж, цөлжилт эрчимтэй явагдаж байгаа бүс нутгийн 70-аас доошгүй хувьд хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулах.

-Хөрсний чийг, таримал болон бэлчээрийн ургамлын ургац, гол, мөрөн, нуур, цөөрөм, усан сангийн усны нөөцийг нэмэгдүүлэх.

**Хоёрдугаар үе шат (2021-2024 он)**

-Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг газар болон агаараас явуулж, аймгийн нийт нутаг дэвсгэрийг хамруулах.

- Гол мөрний ай савын өндөрлөг газруудад хур тунадас нэмэгдүүлэх газрын генератор нэмж суурилуулах.

- Цөлжилтийн зэрэглэл бүхий газарт ойн зурвас байгуулах, ургамал тариалах төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн хөрсний элэгдлийг багасгах.

- Иргэд, байгууллагуудын идэвхи оролцоог нэмэгдүүлэн, төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг 30%-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх.

**Зорилт-6:** Уул уурхайн салбарт баримтлах аймгийн бодлогыг шинэчлэн батлуулж, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаа, хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт үнэлгээ хийж, нөхөн сэргээлтийн ажлыг стандартад нийцүүлэн чанартай хийлгэнэ.

**Нэгдүгээр үе шат (2017-2020 он)**

-Хууль бус олгогдсон түгээмэл тархацтай болон ашигт малтмалын хайгуулын, ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг цуцлуулах.

-Хайгуул ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдоогүй газрыг тусгай хамгаалалтанд авах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх.

-Уул уурхайн үйлдвэрлэлд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, Орон нутгийн хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулан ашигт малтмал, эрдэс баялгийн үр өгөөжийг орон нутгийнхаа иргэдэд хүртээх боломжийг судалж шийдвэрлэх.

*-Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэн, олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагыг дэмжих.*

-Уул уурхайн улмаас хөндөгдсөн талбайн 62.8%-д техникийн, 33.5%-д биологийн нөхөн сэргээлт хийлгэх.

-Аймгийн орон нутгийн өмчийн оролцоотой нүүрс боловсруулах үйлдвэртэй болох асуудлыг судлан санал боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх.

- Жоншны ордуудыг түшиглэн баяжуулах үйлдвэр байгуулж, ажлын байр нэмэгдүүлэх ажлыг эхлүүлэх.

#### **Хоёрдугаар үе шат (2021-2024)**

- Уул уурхайн улмаас хөндөгдсөн талбайн 70%-д техникийн, 39,6%-д биологийн нөхөн сэргээлт хийлгэх.

- Аймгийн орон нутгийн өмчийн оролцоотой нүүрс боловсруулах үйлдвэртэй болох асуудлыг эцэслэн шийдвэрлүүлж, үйл ажиллагааг нь жигдрүүлэх.

- Жоншны ордуудыг түшиглэн баяжуулах үйлдвэр байгуулж, ажлын байр нэмэгдүүлэх.

- *Хайрга, дайрга, боржин чулууны орд газрыг түшиглэн боловсруулах үйлдвэр байгуулахыг дэмжих.*

**Зорилт-7:** Аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө”-г хэрэгжүүлж аймгийн нутаг дэвсгэр дэх нэн ховор, ховор амьтныг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө болон сум дамжсан агнуурын амьтны тархац нутагт ан амьтныг агнах, барих агнуурын бүс нутгийг тогтоож, менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.

#### **Нэгдүгээр үе шат (2017-2020 он)**

-Аймгийн агнуурын бүс нутгуудыг нарийвчлан тогтоож, ховор, нэн ховор ан амьтанг

тархац нутгаар нь хамгаалж, нөхөн үржүүлэн, эдийн засгийн эргэлтэд оруулах.

-Биологийн олон янз байдлын удмын санг хамгаалах, тархац нутаг, амьдрах орчныг тэтгэн, хомсдоос сэргийлж, ашиглалтын нөөц бүрдүүлэх.

-Ан амьтан, жигүүртэн шувуудыг хамгаалах, зохистой ашиглах, өсгөн үржүүлэх бодлогыг шинэчлэн батлуулж, хэрэгжүүлэх.

-Ан амьтан сэргээн нутагшуулах төслүүдийг хэрэгжүүлэх /Гарвага, Загас, Шувуу/.

#### **Хоёрдугаар үе шат (2021-2024)**

-Ан амьтны паркттай болох.

## **2.4. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗАСАГЛАЛ**

**ЗОРИЛГО 1:** Төрийн бодлогын залгамж чанар, салбар хоорондын уялдааг хангасан хөгжлийн удирдлага зохион байгуулалтын тогтолцоог сайжруулан, тогтвортой, хариуцлагатай, ёс зүйтэй, чадварлаг төрийн албыг төлөвшүүлж, батлан хамгаалах чадавхийг бэхжүүлэн, гадаад харилцааг эдийн засагжуулж, олон улсын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлнэ.

**Зорилт 1: Бүх үе шатанд (2017-2024 он):** Нутгийн өөрөө удирдах байгууллага болон бүх шатны төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулан, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлнэ.

**Зорилт 2: Бүх үе шатанд (2017-2024 он):** Салбар бүрд батлагдан хэрэгжиж байгаа бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоог хангаж, боловсронгуй болгон, төрийн бодлогын залгамж чанарыг хадгална.

**Зорилт 3: Бүх үе шатанд (2017-2024 он):** Нутгийн өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлж, төлөөлөгчдийн чадавхийг сайжруулах.

**Зорилт 4: Бүх үе шатанд (2017-2024 он):** Мэдлэг чадвар, туршлагатай ахмад мэргэжилтэн, зөвлөхүүдийн холбоог байгуулан, дунд болон залуу үедээ зөвлөгөө, туршлагаасаа хуваалцах бололцоог бүрдүүлэн, хэрэгжүүлж, нутгийн удирдлагын байгууллагуудын боловсон хүчний чадавхийг сайжруулна.

**Зорилт 5:** Төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлэн, хөдөөгийн иргэдийг сум, багийнхаа үйл ажиллагаанд орон зайн тэгш бус байдлаас үл хамааран жигд оролцох, зардал багатайгаар төрийн үйлчилгээг шуурхай авах, мэдээллээр хангагдах боломжийг бүрдүүлнэ.

**Бүх үе шатанд (2017-2024 он):**

-“Баг” төслийг шинэчлэн боловсруулж, багийн “Явуулын төв”-өөр иргэдэд хүрч үйлчлэн, төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх.

-“Нэг цэгийн үйлчилгээ”-г боловсронгуй болгож иргэдэд үзүүлэх үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх.

-Аймгийн төвд төрийн үйлчилгээний нэгдсэн төв байгуулан, үйл ажиллагааг жигдрүүлэх.

**Зорилт 6:** Тогтвортой хөгжлийн зорилтуудад чиглэсэн дотоод, гадаад харилцаа хамтын ажиллагааг эдийн засагжуулах бодлогыг тэргүүлэх чиглэл болгон, олон талт хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлнэ.

**Бүх үе шатанд (2017-2024 он):**

-Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, таталцлын орчинг хөгжүүлэх бодлогын хүрээнд Засгийн газар, Нийслэлийн удирдлагатай тогтвортой нягт хамтын ажиллагааг хэрэгжүүлэх.

-Хил залгаа улсын мужуудтай ХАА, хөнгөн үйлдвэрлэлийн салбарт хамтын ажиллагаа тогтоох.

-Харилцаат мужуудтай хамтран залуучуудыг хөдөө аж ахуй, газар тариалан, барилгын үйлдвэрлэлийн чиглэлээр 2 жилийн хугацаатай ажилтан дадлагажуулах хөтөлбөрт хамруулах.

-Ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг муж хотуудтай хамтын ажиллагаа тогтоож туршлага солилцох.

**Зорилт 7: Бүх үе шатанд (2017-2024 он):** Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудыг албан хэргээ кирил болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих бэлтгэлийг хангана.

**Зорилт 8: Бүх үе шатанд (2017-2024 он):** Нутгийн удирдлагын бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэн, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг орон нутгийн түвшинд бүрдүүлнэ.

**Зорилт 9: Бүх үе шатанд (2017-2024 он):** Төрийн албыг “Мерит” зарчимд тулгуурлан хууль ёсыг дээдэлсэн, улс төрөөс хараат бус, өндөр ёс зүйтэй, хариуцлагатай, мэргэшсэн чадварлаг болгоход анхаарч, төрийн албан хаагчдыг бэлтгэх, сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх танхимын болон зайн сургалтын хамрах хүрээг нэмэгдүүлж, үр дүнд суурилсан урамшуулал, хариуцлага тооцох тогтолцоог сайжруулна.

**Зорилт 10: Бүх үе шатанд (2017-2024 он):**Төрийн байгууллагуудад цахим засаглал хөтөлбөр хэрэгжүүлж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлнэ.

**Зорилт 11: Бүх үе шатанд (2017-2024 он):** Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах ажлыг мэргэжлийн удирдлагаар ханган, сургалт, сурталчилгаа, үйл ажиллагаанд иргэдийг оролцуулан, тэдний мэдлэг, чадварыг



дээшлүүлэх, аюулгүй амьдрах ухамсарт соёл болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхийг бэхжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулна.

**Зорилт 12: Бүх үе шатанд (2017-2024 он):** Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ хэрэглэх, бизнес эрхлэх таатай орчинг бий болгоход үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн төрийн захиргааны мэргэжлийн хяналтыг орон нутгийн түвшинд хэрэгжүүлнэ.

**Зорилт 13: Бүх үе шатанд (2017-2024 он):** Батлан хамгаалах нь бүх нийтийн үйл хэрэг байх зарчимд тулгуурлан орон нутаг дахь Цэргийн штабын үйл ажиллагааг эрчимжүүлэн, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэн нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгааны тогтолцоог төгөлдөржүүлнэ.

**ЗОРИЛГО 2:** Төрийн байгууллагын үйл ажиллагааг үр дүнд суурилсан гүйцэтгэлээр үнэлэн, төрийн бүх үйлчилгээнд нэгдсэн стандарт тогтооно.

**Зорилт 1: Бүх үе шатанд (2017-2024 он):** Үр дүнд суурилсан хяналт шинжилгээний арга зүйг байгууллага орон нутгийн хэмжээнд нэвтрүүлж, бодит гүйцэтгэл үр дүнг сайжруулна.

**Зорилт 2: Бүх үе шатанд (2017-2024 он):** Аймгийн хэмжээнд төрийн бүх үйлчилгээнд нэгдсэн стандарт тогтоож, дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүйг хэрэгжүүлэх замаар чадварлаг, ёс суртахуунтай мэргэшсэн төрийн албыг бий болгоно.

**Зорилт 3: Бүх үе шатанд (2017-2024 он):** Төсвийн зарцуулалтад хийх, санхүүгийн хяналтын үр нөлөөг дээшлүүлж, эрсдлийн удирдлагаар хангаж ажиллана.

**ЗОРИЛГО 3:** Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд технологийн шинэчлэл нэвтрүүлж, эрх зүйн сургалт сурталчилгааны үр дүнг дээшлүүлэн, төрөөс үзүүлж буй бүртгэл, мэдээллийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй, чанартай, шуурхай хүргэхэд анхаарч орчин үеийн шинэ бүртгэлийн системийг нэвтрүүлнэ.

Иргэдийг эрүүл аюулгүй, амар тайван орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлж, бүх нийтийн оролцоог хангасан хууль ёст хүний эрхийг эрхэмлэн, дээдэлсэн, авлигаас ангид төрийн үйлчилгээг төлөвшүүлнэ.

**Зорилт 1: Бүх үе шатанд (2017-2024 он):** Эрх зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх чадвар дадалтай сургагч багш нарыг мэрэгшүүлэх замаар иргэд, байгууллагад үзүүлэх эрх зүйн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлнэ.

**Зорилт 2: Бүх үе шатанд (2017-2024 он):** Нутгийн удирдлагын үйл ажиллагааг иргэдэд ил тод нээлттэй мэдээлж, нийгмийн бүх давхаргын оролцоотой, хариуцлагатай шийдвэр гаргах тогтолцоог бүх шатанд нэвтрүүлнэ.

**Зорилт 3: Бүх үе шатанд (2017-2024 он):** Хүний эрхийг хамгаалах тогтолцоог сайжруулан, хандлагыг өөрчилж, бүх шатанд иргэдийн эрхийг аливаа хэлбэрээр зөрчихгүй байх нөхцөлийг хангана.

**Зорилт 4: Бүх үе шатанд (2017-2024 он):** Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, төрийн байгууллагын үйл ажиллагаа, албан тушаалтны ёс зүйд хяналт тавих зорилго бүхий “Олон нийтийн дэд зөвлөл”-ийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дэргэд байгуулан ажиллуулна.

**Зорилт 5:** Төрийн архивын баримт бичгийг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх замаар төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулна.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

-Төрийн архивын сан хөмрөгийн баримтын 42.8%-ийг цахим санд шилжүүлэх.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Төрийн архивын сан хөмрөгийн баримтын 70.8%-ийг цахим санд шилжүүлэх.

-Мэдээллийн эрэлт хэрэгцээ ихтэй төрийн архивын томоохон хөмрөгүүдэд сэдэвчилсэн боловсруулалт хийж, архивын хоёрдогч мэдээллийн сан үүсгэх эхлэлийг тавих.

**Зорилт 6:** Хууль сахиулах байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулан, хүний нөөц, техник тоног төхөөрөмж, дэд бүтэц, ажиллах нөхцлийг шинэчлэн, хуульд заасан үүргээ стандартын дагуу хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

-Олон улсын нисэх онгоцны буудалд цагдаагийн хэсгийг шинээр байгуулж, иргэдийн аюулгүй орчинд аялаж, зорчих нөхцлийг бүрдүүлэх.

-Шүүхийн шинжилгээний чанарыг дээшлүүлж, тоног төхөөрөмжөөр хангагдсан стандартад нийцсэн байр, гистологийн лабораторитой болох.

-Улсын бүртгэлийн хэлтсийг жишиг байртай болгож, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны хамгаалалтын хашаа, шалган нэвтрүүлэх байрыг ашиглалтанд оруулж, ажилчдын ажиллах нөхцлийг сайжруулах.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Цагдаагийн газрыг жишиг байртай болгож, ажиллах нөхцлийг сайжруулах.

**Зорилт 7:** Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, олон нийтийн үйл ажиллагааг өргөжүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл болгож, бүтэц, зохион байгуулалтыг бэхжүүлэх, техник технологийг шинэчлэх, олон нийтийн оролцоог хангах чиглэлээр цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

-Цагдаагийн байгууллагын дотоод холбоо, мэдээллийн нэгдсэн систем болон бэлэн бус торгуулийн системийг цагдаагийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлж, цагдаагийн байгууллагын түргэн шуурхай, иргэдэд чирэгдэлгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

-Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэн, хуулийн этгээдийн оролцоог нэмэгдүүлж, олон нийтийн цагдаагийн ажилтанд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, дэмжих, урамшуулах асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх.

-Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хууль сахиулах болон нутгийн захиргааны байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах.

-Гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах зорилгоор гарсан гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, инновацийг хөгжүүлэх замаар гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг шинэ шатанд гаргах.

-Цагдан хорих байрны нөхцлийг хууль, тогтоомжид заасан хүний эрхийг хангасан, аюулгүй байдлын шаардлагын түвшинд хүргэх.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Стандартын шаардлага хангаж, эрүүл аюулгүй орчин бүрдсэн эрүүлжүүлэх, баривчлах, түр саатуулах байр барьж ашиглалтад оруулах.

**Зорилт 8:** Иргэдэд төрийн бүртгэлийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэж, цахим засаглал хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

**Нэгдүгээр үе шат /2017-2020 он/:**

- Хүн амын төвлөрөл ихтэй сумдад улсын бүртгэлийн онлайн сүлжээ нэвтрүүлэх.

**Хоёрдугаар үе шат /2021-2024 он/:**

-Иргэний болон хуулийн этгээдийн архивын цаасан баримтыг цахимжуулах ажлыг дуусгаж, бүртгэлийн дотоод хэрэглээ болон онлайн орчинд ашиглах боломжийг бүрдүүлэх.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ: АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙХ ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭ.**

-Аймгийн хөгжлийн хэтийн зорилтод тусгагдсан зорилго, зорилтуудын биелэлтийг аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил, жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, салбар бүрийн хөгжлийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөнд тусган, хэрэгжилтийн үр дүнг дор дурдсан “**“ХӨГЖЛИЙН ТҮҮЧЭЭ-ТӨВ АЙМАГ-2024”** аймгийн хөгжлийн хэтийн зорилго, зорилтуудын үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтүүд”/44 шалгуур үзүүлэлтээр/-ээр дүгнэнэ.

-Хэтийн зорилтын хэрэгжилтийн явцыг 2 жил тутам аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд, үр дүнг 4 жил тутам аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанд тус тус тайлагнана.

**“ХӨГЖЛИЙН ТҮҮЧЭЭ-ТӨВ АЙМАГ”-2024 ХӨГЖҮҮЛЭХ ХЭТИЙН ЗОРИЛГО,  
ЗОРИЛТУУДЫН ҮР ДҮНГ ТООЦОХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

№	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	Хэмжих нэгж	Суурь үзүүлэлт	ЗОРИЛТОТ ТҮВШИН				
			2016	2018	2020	2022	2024	
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ	тэрбум.төг	546.5	637.4	743.5	932.6	1169.9	
2	Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн	мян.төг	5887.0	5970.6	6056.0	6605.8	7205.6	
3	Өрхийн дундаж бодит орлого	мян.төг	725.1	782.8	857.2	938.6	1027.8	
4	Нийт өрхөд дундаж ба дунджаас дээш амьдарлын түвшинтэй өрхийн эзлэх хувь	хувиар	68.2	72.6	76.9	81.2	85.5	
5	Дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсруулах салбарын эзлэх хувь	хувиар	12.1	13.0	15.0	18.0	20.0	
6	Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт	хувиар	8	8	8	12	12	
7	Малын тооны өсөлт	сая.толгой	4.7	4.8	4.9	5.0	5.1	
8	Сүргийн бүтэц /нийт мал сүрэгт эзлэх хувь/	хувиар	Тэмээ-0.1 Адуу-8.1 Үхэр-6.9 Хонь-51.9 Ямаа-33.0	Тэмээ-0.1 Адуу-8.0 Үхэр-7.3 Хонь-52.6 Ямаа-32.0	Тэмээ-0.1 Адуу-8.0 Үхэр-7.5 Хонь-52.9 Ямаа-31.5	Тэмээ-0.2 Адуу-8.0 Үхэр-8.0 Хонь-53.4 Ямаа-30.4	Тэмээ-0.2 Адуу-8.0 Үхэр-8.6 Хонь-54.0 Ямаа-29.2	
9	Бэлчээр усжуулалтын түвшин	Хувиар	68	69.5	71	72.5	74	
10	Цөм сүргийн малын тоо	мян.толгой	447.5	541.6	655.2	680.0	705.0	
11	Цөм сүргийн малын нийт мал сүрэгт эзлэх хувь	хувиар	9.5	11.2	13.1	13.3	13.6	
12	Эрчимжсэн аж ахуй:							
	• Аж ахуйн тоо /өссөн дүнгээр/	тоо	355	360	370	380	390	
	• Малын тоо	мян.толгой	26.0	28.5	29.0	32.5	35.6	
13	Газар тариалангийн эргэлтийн талбайн ашиглалт	хувиар	75	80	86	92	98	
14	Тариалсан талбай:	га	<b>96286</b>	<b>103295</b>	<b>110270</b>	<b>114865</b>	<b>119965</b>	
	• Үр тариа	га	83554	89000	93000	96000	100000	
	• Буудай	га	78422	78000	85000	89000	93000	

	• Төмс	га	6129	5580	6155	6250	6350
	• Хүнсний ногоо	га	947	1200	1600	1600	1600
	• Тэжээл	га	5626	7500	9500	11000	12000
	• Жимс жимсгэнэ /өссөн дүнгээр/	га	732	757	787	817	847
15	Хураасан ургац:	тн	<b>170829</b>	<b>242998</b>	<b>310228</b>	<b>341335</b>	<b>382155</b>
	• Үр тариа	тн	85742	137950	169260	182400	200000
	• Буудай	тн	80661	110760	147050	160200	176700
	• Төмс	тн	64696	75330	95403	103125	111125
	• Хүнсний ногоо	тн	8074	13800	23520	24800	28800
	• Тэжээл	тн	12169	15750	21850	30800	42000
	• Жимс жимсгэнэ	тн	148	168	195	210	230
16	Усалгаатай талбайн хэмжээ /өссөн дүнгээр/	га	3279	3790	4179	4300	4500
17	Хүлэмжийн талбайн хэмжээ /өссөн дүнгээр/	м <sup>2</sup>	154.599	155.650	156.800	161.000	165.000
18	Боловсруулсан уринш	га	82359	90000	98000	100000	103000
19	Эрдэс бордоогоор бордсон талбай	га	19240	21410	23604	26000	28700
20	Бүртгэлтэй аж ахуйн нэгж /өссөн дүнгээр/	тоо	1919	1950	2000	2050	2100
21	Идэвхитэй үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага /өссөн дүнгээр/	тоо	1221	1280	1340	1410	1500
22	Шинээр байгуулагдсан жижиг дунд үйлдвэр /өссөн дүнгээр/	тоо	140	154	168	182	196
23	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хэмжээ /зэрэгцүүлэх үнээр/	сая.төг	42.784.9	47.919.0	53.669.3	59.036.2	64.939.8
24	Ахуйн үйлчилгээний орлого	сая.төг	3122.5	3590.8	4201.2	4831.8	5556.5
25	Төсвийн хөрөнгө оруулалтын нийт хэмжээ	тэрбум.төг	7.2	9.3	12.0	15.6	20.3
26	Уул уурхайн зориулалтаар хөндөгдсөн талбайд нөхөн сэргээгдсэн талбайн эзлэх хувь	хувиар	34.7	58.5	62.8	67.0	70.0
27	Тусгай хамгаалалтанд авсан газар нутгийн хэмжээ	мян.га	2.111.4	2.160.0	2.210.0	2.250.0	2.300.0
28	Газар өмчилсөн аймгийн иргэний тоо /өссөн дүнгээр/	тоо	33791	73633	-	-	-

29	Орон сууцны хангамж /Аймгийн хэмжээнд/	хувиар	7.64	9.32	11	13	15
30	Орон сууцны хангамж /Зуунмодны хэмжээнд/	хувиар	38.6	41.8	45	57.5	70
31	Хүн амын тоо	тоо	92832	106757	122770	141180	162360
32	Хүн амын дундаж наслалт	жил	72.06	73.06	74.06	75.6	76.06
33	Ядуурлын түвшин	хувиар	21.6	15.8	12.9	10.0	7.1
34	Ажилгүйдлийн түвшин	хувиар	6.3	5.7	5.4	5.0	4.4
35	Шинээр бий болгосон байнгын ажлын байрны тоо	тоо	1305	1500	1500	1500	1500
36	Эхийн эндэгдлийн түвшин	100000 амьд төрөлтөд	82.1	-	-	-	-
37	Нялхасын эндэгдлийн түвшин	1000 амьд төрөлтөд	20.5	13.3	13	12	11
38	5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийн түвшин	1000 амьд төрөлтөд	30.4	17.2	15	13.5	12
39	Халдварт өвчний түвшин	10000 хүн амд	133.8	117	101	85.0	69.0
40	Цэцэрлэгт хамрагдалт	хувиар	83.4	86.0	87.3	89.0	92.0
41	Сургуульд хамрагдалт	хувиар	84.8	85.7	87.0	89.0	92.0
42	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт	хувиар	0.5	0.6	0.7	0.8	0.9
43	Элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо	тоо	503.6	504	505	507	510
44	Аймгуудын өрсөлдөх чадварын үнэлгээ	эрэмбээр	68	60	55	50	45

----- оОо-----

